



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТАНИЛЦУУЛГА

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2020/03



**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН 2020 ОНЫ 03 САРЫН
ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

1.Макро эдийн засаг



Төсөө санхүү

Аймгийн төсөвт 47.4 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 103.8 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 26.6 хувиар даван биелж, татварын бус орлогын төлөвлөгөө 7.5 хувиар тасарчээ.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 50.2 хувь буюу 17.7 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 3.2 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 7.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 7.4 хувийг хөрөнгийн зардалд, 26.2 хувийг бараа үйлчилгээний зардалд, 55.9 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ.

Салбарын хувьд нийгмийн даатгал, нийгмийн халамж салбарт 0.2 хувийг, эдийн засгийн бусад салбарт 0.9 хувийг, эрүүл мэнд, спортын салбарт 4.1 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 7.4 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 33.0 хувийг, боловсрол, соёл урлагийн салбарт 54.4 хувийг зарцуулсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт зарлага санхүүжилт 2.9 хувиар, орлого 81.2 хувиар их байна.



Банк, мөнгө, зээл

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 332.0 тэрбум төгрөгт хүрч, аймгийн нэг хүнд дунджаар 3179380 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 3138648 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 23.5 хувиар нэмэгдэж, хадгаламж эзэмшигчийн тоо 5.1 хувиар буурчээ.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн сарын хүү 0.43 - 0.6 хувь, хугацаатай хадгаламжийн сарын хүү 0.6 - 1.3 хувь, харин хугацааны эцэст зарласан зээлийн сарын хүү 0.42 - 3.0 хувьтай байна.

Банк бус санхүүгийн 2 байгууллага, 7 хадгаламж зээлийн хоршоод 659 хадгаламж эзэмшигчийн 3.4 тэрбум төгрөгийн хадгаламжийг төвлөрүүлж, 573 иргэн, аж ахуйн нэгжид 1.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Өмнөх оны мөн үеэс олгосон зээлийн хэмжээ 22.9 хувиар, зээлжигчийн тоо 30.9 хувиар буурч, хадгаламж 19.4 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 12.6 хувиар нэмэгджээ.



Гадаад худалдаа

Тайлант хугацаанд гадаад худалдааны нийт эргэлт 615.4 тэрбум төгрөгт хүрсний 87.2 хувийг экспорт, 12.8 хувийг импорт эзэлж байна.

Оны эхний 3 сарын байдлаар 156.1 мян.тн зэсийн баяжмал, 3.1 мян.тн катодын зэс, 1.5 мян.тн молибдены баяжмал зэрэг 536.5 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн экспортолж, 0.5 мян.тн улаанбуудай, тээрмийн ган бөмбөлөг 3.1 мян.тн, бензин 5.6 мян.тн, дизелийн түлш 6.1 мян.тн зэрэг нийт дүнгээр 78.9 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн импортоор авчээ.

Өмнөх оны мөн үеэс экспортолсон зэсийн баяжмал 0.1 хувиар, молибдены баяжмал 7.1 хувиар, катодын зэс 34.8 хувиар, импортолсон тээрмийн ган бөмбөлөг 72.2 хувиар нэмэгдэж, экспортолсон нүүрс 74.6 хувиар, импортолсон дизелийн түлш 44.0 хувиар, бензин 12.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны мөн үеэс гадаад худалдааны нийт эргэлт 4.4 хувиар, экспорт 2.9 хувиар, импорт 15.7 хувиар нэмэгджээ.



Үнэ

Өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тарифын судалгааг хэрэглээний сагс дахь 238 нэр төрлийн бараа үйлчилгээнд хийв. Судалгааны дүнгээр үнийн ерөнхий индекс энэ сард 100.2 хувь болж өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар, 12 сараас 3.1 хувиар өссөн байна.

Өмнөх сараас хувцас бөс бараа, хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, бусад бараа үйлчилгээ, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний бүлгийн индекс 0.2-2.8 хувиар өсч, тээврийн бүлгийн индекс 0.3 хувиар буурсан бол орон сууц гэр ахуйн бараа, холбоо шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээний бүлгийн индекс тогтвортой байна.

Хүнсний барааны бүлгийн индексийн өсөлтөнд “Алтан тариа” гурил 50 төгрөгөөр, махны 1 кг-ын үнэ 200-500 төгрөгөөр, хүнсний ногоо 200-500 төгрөгөөр өссөн нь, бусад бараа үйлчилгээний бүлгийн өсөлтөнд Zero үзгэн балны үнэ 200 төгрөгөөр, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн индексийн өсөлтөнд 1 уут "С" витамин үнэ 50 төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



Ажил эрхлэлт

Тайлант хугацаанд нийт 390 ажлын байр бий болсны 59.5 хувь нь шинээр бий болжээ.

Ажлын байраар хангагдагсдын 28.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 21.5 хувь нь худалдааны салбарт, 19.7 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 5.1 хувь нь боловсролын салбарт, 3.3 хувь нь зочид буудал, зоогийн газарт ажиллаж байна. Шинээр бий болсон ажлын байрны 29.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 35.3 хувь нь худалдааны салбарт бий болжээ.

Тайлант хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 1453 хүн бүртгэлтэй байгаагийн 57.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар буюу 276 хүнээр их байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 14.7 хувь нь 15-24 насныхан, 21.5 хувь нь 45 ба түүнээс дээш насныхан, 27.2 хувь нь 35-44 насныхан, 36.5 хувь нь 25-34 насныхан байна.

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 22.9 хувь нь сургууль төгсөгчид, 9.3 хувь нь өөр газраас шилжин ирэгсэд, 4.8 хувь нь орон тооны цомхотголд орсон хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 52.4 хувийг бүрэн дунд, 28.8 хувийг дээд, 8.2 хувийг мэргэжлийн анхан шатны, 5.4 хувийг тусгай дунд, 3.4 хувийг суурь, 1.1 хувийг бага боловсролтой, 0.8 хувийг боловсролгүй хүмүүс эзэлж байна.

2. Нийгмийн үзүүлэлт



Хүн амын ердийн болон шилжилт хөдөлгөөн

Тайлант хугацаанд төрсөн 496 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 115 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 105 гэрлэлтийг бүртгэн, 36 гэрлэлт цуцлагдаж, 18 хүүхэд үрчлэгджээ. Өмнөх оны мөн үеэс төрөлт 5.0 хувиар, нас баралт 16.7 хувиар, гэр бүл цуцлалт 18.2 хувиар, гэрлэлт 30.0 хувиар буурч, үрчлэлт 28.6 хувиар нэмэгдсэн байна.

Оны эхний 3 сарын байдлаар 520 хүн шилжин ирсэний 30.0 хувь нь Улаанбаатар хотоос, 27.7 хувь нь Булган аймгаас, 6.5 хувь нь Хөвсгөл аймгаас шилжин ирсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Насны хувьд шилжин ирэгсдийн 61.7 хувь нь 15-54 насныхан байна.



Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 54.1 мянган хүнд 27.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.7 мянган хүнд 887.6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1.8 мянган хүнд 480.7 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 0.9 мянган хүнд 219.1 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 2.8 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 115.6 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 28.1 мянган хүнд 1.8 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгожээ.

Өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 22.2 хувиар, олгосон халамжийн хэмжээ 20.8 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгаас 70-аас дээш насны 2.8 мянган ахмад настанд 50.3 сая төгрөгийн сар шинийн хүндэтгэл, 42 иргэнд 11.4 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 58.2 хувиар нэмэгджээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 34.0 тэрбум төгрөг төвлөрүүлснээр, төлөвлөгөө 50.3 хувиар давж биелжээ. Эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн сангийн орлого 2.9-3.9 хувиар тасарч, тэтгэмж, ҮОМШӨ, тэтгэврийн даатгалын сангийн орлого 34.6-70.2 хувиар давж биелсэн байна. Сангийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 45.6 хувиар их байна.

Тайлант хугацаанд 313 хүнд шинээр тэтгэвэр тогтоосноос 79.5 хувьд нь өндөр насны, 17.3 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.2 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоосон нь өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалд 86.2 мянган хүн даатгуулсны 66.1 хувь нь төр төлбөрийг нь даадаг, 33.9 хувь нь заавал даатгуулагсад байна. Өмнөх оны мөн үеэс эрүүл мэндийн даатгалд даатгуулагч 0.3 хувиар нэмэгджээ.



Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 168.2 мянган хүнд үзлэг хийснээс 32.3 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 8.6 хувиар нэмэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг 2.2 хувиар буурчээ.

Сэргийлэх тарилгад 4.3 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 99.2 хувь нь бөгөөд хамралтын хувь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 26.1 мянган хүнд үйлчилснээр өмнөх оны мөн үеэс үйлчлүүлсэн хүний тоо 16.2 хувиар буурсан хэдий ч орлого 2.3 дахин нэмэгджээ.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 635 эх амаржин, 124 хүн нас баржээ. Нас баралтын 5.6 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. 1000 хүнд ногдох төрөлт 0.1 промилээр нэмэгдэж, нас баралт 0.2 промилээр, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 0.1 промилээр буурсан байна. Тайлант хугацаанд эхийн эндэгдэлгүй ажиллав.

Халдварт өвчнөөр өвчилсөн 220 тохиолдол гарсан нь өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буюу 1.2 продицимилээр нэмэгдсэн байна. Нийт өвчлөлтийн 21.8 хувийг тэмбүү, 19.5 хувийг салхинцэцэг, 12.3 хувийг трихоманаз, 11.8 хувийг кандид, 11.4 хувийг заг хүйтэн, 10.9 хувийг сүрьеэ, 6.8 хувийг мөөгөнцөр, 1.8 хувийг суулгалт халдвар, 1.4 хувийг халдварт шар, 0.9 хувийг цусан суулга, 0.5 хувийг хоолны хордлого, 0.5 хувийг халдварт мэнэн, 0.5 хувийг гар, хөл, амны өвчин эзэлж байна. Нийт өвчлөлийн 57.3 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөгсөд байна.

Өмнөх оны мөн үеэс 10000 хүнд ногдох цусан суулга 2.4, суулгалт халдвар 1.6, мөөгөнцөр 1.4, трихоманаз 0.7, хоолны хордлого 0.2, гар, хөл, амны өвчин 0.1 продицимилээр буурч, бусад халдварт өвчний гаралт 0.2-2.4 продицимилээр нэмэгдсэнээс салхинцэцэг 2.4 продицимилээр нэмэгджээ.

Өмнөх оны мөн үед гарч байгаагүй халдварт мэнэнгээр өвчилсөн 1 тохиолдол гарсан байна.



Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 155 хэрэгт 79 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 44.1 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн хэрэг 14.4 хувиар, холбогдогч 4.8 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 3.8 продицимилээр буурч, хэргийн илрүүлэлт 2.1 пунктээр их байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 32.9 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 25.8 хувь нь хүнд гэмт хэрэг, 87.7 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг байгаа ба өмнөх оны мөн үеэс согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.9 хувиар нэмэгдэж, хэрэг бүртгэлтийн хэрэг 19.5 хувиар, хүнд гэмт хэрэг 28.6 хувиар буурчээ.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 45.2 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 20.6 хувийг хулгайлах, 16.1 хувийг залилах, хөрөнгө завших, 3.2 хувийг хүчиндэх, 1.9 хувийг малын хулгай, 1.9 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг, 1.9 хувийг дээрэмдэх хэрэг эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 55.6 хувиар, дээрэмдэх хэрэг 50.0 хувиар нэмэгдэж, хүчингийн болон малын хулгайн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байж, бусад хэргийн гаралт 13.8-66.7 хувиар буурснаас хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 66.7 хувиар буурчээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 430.8 сая төгрөгийн хохирол учирч, 6 хүн нас барж, 77 хүн хүнд ба хөнгөнөөр гэмтжээ. Нийт хохирлын 32.2 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 79 хүний 50.6 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 68.4 хувь нь согтуугаар, 7.6 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 1.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд 738 хүн эрүүлжигдэн, 210 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдсан байна. Өмнөх оны мөн үеэс баривчлагдсан хүний тоо 0.5 хувиар нэмэгдэж, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 8.2 хувиар буурчээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 391 жолоочийг илрүүлж, зөрчил гаргасан 317 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 8.6 хувиар, эрх хасалт 4.3 хувиар нэмэгдсэн байна.

3.Үйлдвэрлэл үйлчилгээ.



Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 509.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 538.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 3.3 хувиар буурч, борлуулалт 0.1 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүний 99.98 хувь нь Баян-Өндөр суманд, 0.02 хувь нь Жаргалант суманд үйлдвэрлэгджээ.

Өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 7.0 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 34.5 хувиар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 5.4 хувиар буурсан байна.

“Эрдэнэт мах маркет” ХХК, “Эрдмийт” ХХК-ийн үйлдвэрлэлт өссөн нь мах, махан бүтээгдэхүүний бүлгийн өсөлтөд, “Баяжуулагч одод” ХХК-ийн үйлдвэрлэлт буурсан нь сүү, сүүн бүтээгдэхүүний бүлгийн бууралтад, “Эрдэнэт фүүдс” ХХК үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь үр тарианы гурил үйлдвэрлэлийн бууралтад, “Дабльголд” ХХК, “Хайтан хишиг” ХХК-г мэдээнд нэмж хамруулсан нь ус, ундааны бүлгийн өсөлтөд, “Гутал буян” ХХК ажлын гутал үйлдвэрлэж эхэлсэн нь арьс шир боловсруулах, гутал үйлдвэрлэлийн өсөлтөд, тамга үйлдвэрлэдэг “Кристал стемп” ХХК-г мэдээнд нэмж хамруулсан нь мод, модон эдлэл үйлдвэрлэлийн өсөлтөд, “Төгс төгөлдөр урлан” ХХК, “Төгсдизайн” ХХК-г мэдээнд нэмж хамруулсан нь хэвлэх үйлдвэрийн өсөлтөд, барилгын хуурай хольц үйлдвэрлэлийн “Пенопасад” ХХК-г мэдээнд нэмж хамруулсан нь химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтөд, “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-ийн РСЦ цехийн үйлдвэрлэлт нэмэгдсэн нь төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэлийн өсөлтөд, “Анд-энерги” ХХК-ийн үйлдвэрлэлт нэмэгдсэн нь цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэлийн өсөлтөд тус тус нөлөөлжээ.

Нийт бүтээгдэхүүний 89.9 хувийг уул уурхайн олборлох, 5.7 хувийг боловсруулах, 4.4 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Гол нэр төрлийн 58 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас зэсийн баяжмал, катодын зэс, бууз, банш, дулааны эрчим хүч, гудас, матрас, хэрчсэн гурил, хивс, хэвийн боов, молибдений баяжмал, сүлжмэл эдлэл, нарийн боов, бялуу, бусад хэвлэмэл зүйлс, талх, гоймон, цэвэр ус, дайвар бүтээгдэхүүн 0.1-84.8 хувиар, хүснэгт маягт, үхрийн мах, хулдаасан хэвлэл, ноолууран алчуур нөмрөг, бетон зуурмаг, зайрмаг, амтат ус ундаа, ноосон хөнжил, хаалга цонх, металл бэлдэц, буриад гутал, хонины мах 2.8-24.8 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 1.2-99.7 хувиар буурсны дотор ноосон алчуур, нөмрөг 99.7 хувиар буурчээ.

Өмнөх оны мөн үеэс аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 5.5 хувиар нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж 8.3 хувиар буурсан байна.



Хөдөө аж ахуй

Оны эхний төллөх эх малын 40.7 хувь буюу 23.6 мянган хээлтэгч мал төллөж,

гарсан төлийн 99.4 хувь нь бойжиж байна. Өмнөх оны мөн үеэс төллөлт 12.8 пунктээр, төлийн хорогдол 13.5 дахин их байна.

Тайлант хугацаанд 87 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.93 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс том малын хорогдол 74.0 хувиар их байна. Баян-Өндөр суманд 63 том мал, Жаргалант суманд 24 том мал хорогдсон байна.

Зүй бусаар хорогдсон том малын 40.2 хувь ямаа, 25.3 хувь нь хонь, 23.0 хувь нь үхэр, 11.5 хувь нь адуу байна.

Аймгийн мал эмнэлгийн байгууллагууд 16.2 мянган толгой малд үзлэг, 2.0 мянган толгой малд туулгалт хийж, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 16.8 мянган толгой малыг хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс үзлэгт хамруулсан мал 2.5 хувиар бага, туулгалт хийсэн мал 3.9 дахин их байна.



Барилга

Тайлант хугацаанд их барилгын салбарт 2 аж ахуй нэгж 4.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 5 объектод хийж гүйцэтгэсэн байна. Өмнөх оны мөн үеэс гүйцэтгэсэн ажлын дүн 5.2 хувиар нэмэгджээ.



Тээвэр, холбоо

Авто тээврийн байгууллагууд 28.1 мян/тн ачаа тээвэрлэн, 11.3 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 1.1 сая зорчигч тээвэрлэн, 18.1 сая.хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, авто тээврийн үйлчилгээнээс 3.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 26.1 хувиар, ачаа эргэлт 13.7 хувиар, тээсэн зорчигч 25.6 хувиар, зорчигч эргэлт 31.0 хувиар буурчээ. Зорчигч тээврийн үйлчилгээнд 369 такси, 4 микроавтобус, 49 автобус гарч, тэдгээрт 711 хүн ажиллаж байна.

Холбооны байгууллагууд 1.8 тэрбум төгрөгийн тарифын орлоготой ажилласны 98.0 хувь нь хүн амын үйлчилгээний орлого байна. Өмнөх оны мөн үеэс кабелийн телевизийн орлого 5.1 хувиар, төмөр замын холбооны орлого 6.1 хувиар, мэдээлэл холбооны сүлжээний орлого 6.8 хувиар нэмэгдэж, үүрэн телефон, Монголын цахилгаан холбоо, интернэтийн орлого 3.4-11.6 хувиар буурчээ.

Интернэт үйлчилгээний 2 цэг давхардсан тоогоор 3.4 мянган хүнд үйлчилгээ үзүүлжээ.



Худалдаа, үйлчилгээ

Худалдаа, нийтийн хоолны 652 цэг салбар 31.2 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгджээ.

Нийт бараа гүйлгээний 43.9 хувийг хүнсний дэлгүүр, 25.8 хувийг шатахууны борлуулалт, 10.8 хувийг зоогийн газар, 9.1 хувийг барааны дэлгүүр, 9.1 хувийг эм борлуулалт, 0.6 хувийг авто засварын газар, 0.4 хувийг контейнер, 0.2 хувийг барилгын материалын дэлгүүр, 0.1 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс контейнер, эм борлуулалт, авто сэлбэгийн дэлгүүр, хүнсний дэлгүүр, барааны дэлгүүр, авто засварын газрын орлого 0.8-72.9 хувиар, ТҮЦ-ний орлого 12.4 дахин өсч, шатахуун борлуулалт 12.8 хувиар, зоогийн газрын орлого 29.0 хувиар, барилгын материалын дэлгүүрийн орлого 58.4 хувиар буурчээ. Нийт бараа гүйлгээний 98.5 хувь нь Баян-Өндөр суманд хийгдсэн байна.

Аймгийн зоогийн газрын 115 цэг салбар 3.4 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 29.0 хувиар, үүнээс ресторан, баарны орлого 45.0 хувиар буурчээ. Нийтийн хоолны бараа гүйлгээний 40.4 хувийг ресторан, баарны орлого эзэлж байна.



Нийтийн аж ахуйн үйлчилгээ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого 5.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.1 хувиар нэмэгдсэн байна. Нийт орлогын 49.0 хувийг орон сууцны, 42.4 хувийг аж ахуйн нэгж албан газрын, 4.6 хувийг зочид буудлын, 1.9 хувийг хог тээвэрлэлтийн, 1.2 хувийг зөөврийн ус борлуулалтын, 0.7 хувийг сауны, 0.3 хувийг халуун усны орлого бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үеэс зөөврийн цэвэр усны борлуулалт, хог тээвэрлэлт, орон сууцны болон аж ахуйн нэгж албан газар, халуун усны орлого 9.1 – 36.8 хувиар нэмэгдэж, зочид буудал, сауны орлого 9.9 – 48.6 хувиар буурчээ. Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлогын 99.7 хувийг Баян-Өндөр сум эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний салбарт 450.2 сая төгрөгийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар бага байна.

Нийт орлогын 52.1 хувийг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 32.7 хувийг үсчин, 9.2 хувийг хими цэвэрлэгээ, 2.3 хувийг прокат ба тоглоомын цэг, 1.8 хувийг гутал засвар, 1.3 хувийг гэрэл зураг, 0.5 хувийг телевизор болон цаг засварын орлого эзэлж байна.

Ахуйн үйлчилгээний орлогын 99.8 хувийг Баян-Өндөр сум бүрдүүлжээ.

Тайлант хугацаанд сууц өмчлөгчдийн холбоод 348.6 сая төгрөгийн орлого, 546.9 сая төгрөгийн зарлагатай ажилласан нь өмнөх оны мөн үеэс орлого 10.8 хувиар, зарлага 78.3 хувиар нэмэгджээ. Барилгын засвар үйлчилгээний зардалд 74.4 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 76.7 хувиар их байна. Нийт зардлын 13.6 хувийг барилгын засвар үйлчилгээнд зарцуулжээ.



Бусад мэдээлэл

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлж эхэлсэн хугацаанд хүсэлт гаргасан 22.5 мянган өрхөд 1583.86 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлснээс 1084.0 га газрыг энэ оны 1-р улиралд өмчлүүлсэн байна. Газар хүссэн өрхийн хүсэлтийн 90.7 хувийг барагдуулж, газрын төлбөрт 4.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур -3.9 хэмийн хүйтэн байж, өмнөх оны мөн үеэс -1.6 хэмээр хүйтэн, хур тунадас 1.8 мм-ээр их байна. Агаарын чанарын MNS4585:2007 стандартад харьцуулан үзэхэд хүхэрлэг хий (SO₂), нүүрстөрөгчийн дутуу исэл(CO) стандартаас даваагүй байна.



Бүртгэл, хяналт шалгалт


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр тайлант хугацаанд 81 аж ахуйн нэгж шинээр байгуулагдан, 7 аж ахуйн нэгж хасагдсанаар (татан буугдсан, шилжсэн) аж ахуйн нэгж, байгууллагын тоо 5004 болж, өмнөх оноос 1.5 хувиар буюу 74-өөр нэмэгджээ.

Энэ улиралд талх, нарийн боов үйлдвэрлэлийн “Хайтан хишиг” ХХК, тамга үйлдвэрлэлийн “Кристал стемп” ХХК, хэвлэлийн “Төгс төгөлдөр урлан” ХХК, барилгын хуурай хольц үйлдвэрлэлийн “Пенопасад” ХХК-г статистикийн мэдээнд шинээр нэмж хамрууллаа.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг

	2016	2017	2018	2019	2020			$\frac{2020}{2019}$ %
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
Нийт орлого	19 740.4	21 276.1	22 310.5	26 182.4	45 709.6	47 433.1	103.8	181.2
Урсгал орлого	19 740.4	21 276.1	22 310.5	26 182.4	45 709.6	47 433.1	103.8	181.2
Татварын орлого	10 970.3	12 315.6	12 611.1	15 943.6	15 083.3	19 100.6	126.6	119.8
Орлогын албан татвар	6 950.9	7 619.2	8 047.5	9 032.6	8 380.6	11 517.1	137.4	127.5
- Хүн амын орлогын албан татвар	6 950.9	7 619.2	8 047.5	9 032.6	8 380.6	11 517.1	137.4	127.5
Үүнээс: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал	-	7 306.6	7 182.1	7 703.0	7 300.0	10 004.2	137.0	129.9
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-	-	-	-	-	-	-
Хөрөнгийн албан татвар	1 771.7	2 242.4	2 269.6	2 233.7	2281.5	2335.3	102.4	104.5
Бусад татвар	2 247.7	2 454.0	2 294.0	4 677.3	4 421.2	5 248.2	118.7	112.2
Татварын бус орлого	8 770.1	8 960.5	9 699.4	10 238.8	30 626.3	28 332.5	92.5	2.8 ²

Тайлбар: ² - Дахин их





ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, зардлаар, сая төгрөг

	2016	2017	2018	2019	2020			2020% 2019
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зардал	17 289.3	14 712.9	15 212.7	17 202.5	35 292.0	17 708.8	50.2	102.9
Цалин хөлс	6 100.6	6 260.4	6 391.8	8 033.4	10 433.8	9 894.4	94.8	123.2
Нийгмийн даатгалын шимтгэл	662.6	675.0	767.4	1 006.7	1392.3	1295.7	93.1	128.7
Бараа үйлчилгээний зардал	3 793.3	3 574.1	3 865.2	4 824.5	6 381.8	4 631.6	72.6	96.0
Татаас ба урсгал шилжүүлэг	3 257.2	2 847.2	2 529.6	2 022.4	5 775.4	568.3	9.8	28.1
Хөрөнгийн зардал	3 475.6	1 356.2	1 658.7	1 315.5	11 308.7	1318.8	11.7	100.3

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, салбараар, сая төгрөг

	2016	2017	2018	2019	2020			2020% 2019
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зардал	17 289.3	14 712.9	15 212.7	17 202.5	35 292.0	17 708.8	50.2	102.9
Нийтийн ерөнхий үйлчилгээ	3 644.6	3 587.4	4 021.3	6 447.1	11 222.4	5 845.3	52.1	90.7
Боловсрол, соёл урлаг	6 462.3	6 627.9	6 972.3	8 192.6	11 788.5	9 626.3	81.7	117.5
Эрүүл мэнд, спорт	394.3	392.9	410.2	502.1	735.0	732.2	99.6	145.8
Нийгмийн даатгал, нийгмийн халамж	3 207.2	2 638.8	2 027.9	582.7	32.1	32.1	100.0	5.5
Эдийн засгийн бусад салбарт	105.3	109.7	122.3	162.5	205.3	154.1	75.1	94.8
Ангилалдаагүй бусад зардал	3 475.6	1 356.2	1 658.7	1 315.5	11 308.7	1318.8	11.7	100.3



БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ, сая төгрөг

		2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Кассын орлого	МБ-ны зузаатгалаар *	37 126.0	33 987.0	32 794.4	-	-	-
	Гүйлгээнээс татсан *	340 196.8	362 245.4	427 535.4	438 223.7	-	-
Кассын зарлага	МБ-нд шилжүүлсэн *	28 603.0	30 443.1	31 396.6	-	-	-
	Гүйлгээнд гаргасан *	349 404.5	375 879.4	435 953.2	425 671.4	-	-
Зээлийн өрийн үлдэгдэл		203 860.9	231 503.0	267 927.8	339 062.9	318 386.1	93.9
Хугацаа хэтэрсэн зээл		4 827.5	2 587.7	3 592.3	4 864.6	7 631.6	156.9
<i>Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		2.4	1.1	1.3	1.4	2.4	1.0
Чанаргүй зээл		3 489.9	5 343.3	3 935.0	5 959.2	5 703.1	95.7
<i>Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		1.7	2.3	1.5	1.8	1.8	0.0
Иргэдийн мөнгөн хадгаламжийн үлдэгдэл		146 526.9	186 476.8	215 426.3	268 764.9	331 164.0	123.2
1 хүнд ногдох хадгаламж (мян.төг)		1 552.2	1 830.2	2 119.3	2 619.0	3 171.7	121.1
1 хадгаламж эзэмшигчид ногдох хадгаламж (мян.төг)		1 388.4	1 652.9	1 931.1	2 412.0	3 122.4	129.5

Тайлбар: * Төрийн болон албаны нууцын тухай хуулиар байгууллагын нууцын жагсаалтад орсон учир мэдээлэл гарахгүй.

АРИЛЖААНЫ БАНКНЫ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ


2020.03.31-ний байдлаар

	Хадгаламжийн хүүний дундаж хувь				Хугацааны эцэст зарласан зээлийн хүү
	Төгрөгийн		Долларын		
	Хугацаагүй	Хугацаатай	Хугацаагүй	Хугацаатай	
Хаан банк	0.45	0.65-1.23	0.12	0.2-0.45	1.5-2.5
Голомт банк	0.6	0.7-1.3	0.25	0.3-0.43	0.67-2.95
ХХБанк	0.5	0.6-1.22	0.16	0.22-0.47	0.67-2.5
Төрийн банк	0.5	0.65-1.3	0.17	0.18-0.55	0.67-3.0
Хас банк	0.43	1.1-1.3	0.28	0.28-0.46	0.42-2.0
Богд банк	0.55	0.6-1.14	0.12	0.22-0.45	1.6-2.4
Капитрон банк	0.55	0.7-1.3	0.17	0.25-0.5	0.58-2.6

ГАДААД ХУДАЛДАА

Үзүүлэлт	хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Нийт эргэлт	тэрбум. төг	366.2	524.7	635.5	589.4	615.4	104.4
	сая.ам доллар	180.8	211.9	263.6	223.4	223.3	100.0
Нийт экспорт	тэрбум. төг	313.6	484.8	589.7	521.2	536.5	102.9
	сая.ам доллар	154.8	195.8	244.6	197.5	194.7	98.6
Зэсийн баяжмал	мян.тн	158.4	160.5	162.9	156.0	156.1	100.1
Молибдены баяжмал	мян.тн	1.5	1.7	1.4	1.4	1.5	107.1
Катодын зэс	мян.тн	3.5	4.1	3.5	2.3	3.1	134.8
Хивс	мян.м2	10.9	5.7	0.5	4.6	-	
Малын хөлдүү мах	тн	40.0	-	100.0	55.3	-	
Тосны ургамал	тн	-	-	-	-	-	
Нүүрс, боловсруулаагүй	мян.тн	-	-	21.9	13.0	3.3	25.4
Нийт импорт	тэрбум. төг	52.6	39.9	45.8	68.2	78.9	115.7
	сая.ам доллар	26.0	16.1	19.0	25.9	28.6	110.4
Тээрмийн ган бөмбөлөг	мян.тн	2.2	1.4	3.5	1.8	3.1	172.2
Дизелийн түлш	мян.тн	2.5	6.6	3.7	10.9	6.1	56.0
Бензин	мян.тн	4.9	4.1	4.1	6.4	5.6	87.5
Улаанбуудай, зөөлөн	мян.тн	2.2	-	2.6	-	0.5	
Авто машин	ш	-	-	-	-	-	

Импортын барааны бүтэц, 2020 он




Экспортын барааны бүтэц, 2020 он



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс , 2020 оны 03 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	$\frac{2020.03}{2019.03}$	$\frac{2020.03}{2019.12}$	$\frac{2020.03}{2020.02}$
Ерөнхий индекс	104.6	103.1	100.2
Хүнсний бараа, ундаа , ус	107.6	110.2	100.4
Согтууруулах ундаа, тамхи	102.1	101.3	100.3
Хувцас, бөс бараа, гутал	105.6	101.0	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.3	100.1	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	103.0	101.3	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	104.7	103.3	100.5
Тээвэр	101.0	99.7	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	102.8	102.8	102.8
Боловсролын үйлчилгээ	105.3	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.4	101.6	101.0



НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР, эдийн засгийн салбараар

Эдийн засгийн салбар	2016	2017	2018	2019	2020	шинээр бий болсон
БҮГД	308	98	226	377	390	232
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	7	-	4	10	21	19
Уул уурхай, олборлолт	9	-	1	5	6	-
Боловсруулах үйлдвэрлэл	41	6	43	77	112	69
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3	-	2	5	4	4
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2	-	8	1	4	4
Барилга	16	-	-	4	7	6
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	27	9	48	35	84	82
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5	-	7	1	9	3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	11	4	48	54	13	11
Мэдээлэл, холбоо	2	-	2	2	-	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	12	1	14	5	5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12	-	-	3	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	16	-	20	3	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	12	23	7	35	12	5
Боловсрол	90	21	7	22	20	2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	8	3	10	17	8	2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2	-	-	1	5	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	55	4	38	71	77	19
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	-	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр авав.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
БҮГД	2 422	1 751	1 231	1 177	1 453	123.4
<i>эмэгтэй</i>	1 318	966	674	673	841	125.0
Ажилгүйчүүд насны бүлгээр						
15 - 24	516	280	237	186	214	115.1
25 - 34	1 018	739	480	426	531	124.6
35 - 44	508	390	302	298	395	132.6
45,+	380	342	212	267	313	117.2

НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
БҮГД	308	98	226	377	390	103.4
<i>эмэгтэй</i>	197	65	141	263	256	97.3
Төрийн, төсөвт байгууллага	96	57	17	55	30	54.5
Компани, нөхөрлөл	187	33	163	180	185	102.8
Хоршоо	1	-	-	-	-	
Бусад	24	8	46	142	175	123.2

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН АЖИЛГҮЙЧҮҮД

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Нэмэгдсэн ажилгүйчүүд	1 937	950	1 184	881	892	101.2
<i>эмэгтэй</i>	1 125	567	638	549	538	98.0
Орон тооны цомхотголоос	259	180	70	28	43	153.6
Байгууллага татан буугдсанаас	101	31	20	13	13	100.0
Өөр газраас шилжин ирсэн	211	99	109	149	83	55.7
Сургууль төгссөн	620	211	390	171	204	119.3
Цэргээс халагдсан	32	8	16	3	7	2.3 ²
Цалин багатайгаас	102	47	131	89	109	122.5
Бусад	612	374	448	428	433	101.2

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр авав.

Тайлбар: ²-Дахин их


БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролоор

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Бүртгэлтэй ажилгүйчүүд - бүгд	2 422	1 751	1 219	1 177	1 453	123.4
<i>Дээд</i>	864	656	298	298	418	140.3
<i>Тусгай дунд</i>	119	93	75	39	78	2.0 ²
<i>Мэргэжлийн анхан шатны</i>	204	135	124	81	119	146.9
<i>Бүрэн дунд</i>	1 127	804	654	704	761	108.1
<i>Суурь</i>	89	48	45	29	49	169.0
<i>Бага</i>	12	10	15	12	16	133.3
<i>Боловсролгүй</i>	7	5	8	14	12	85.7

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр авав.

Тайлбар: ²-Дахин их

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролын түвшингээр, бүтцээр



ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН



	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Төрсөн хүүхдийн тоо	562	469	616	522	496	95.0
Нас барсан хүний тоо	148	96	169	138	115	83.3
Бүртгүүлсэн гэр бүлийн тоо	174	129	202	150	105	70.0
Цуцалсан гэр бүлийн тоо	51	40	54	44	36	81.8
Үрчлэгдсэн хүүхдийн тоо	11	16	14	14	18	128.6

ШИЛЖИН ИРЭГСЭД

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Шилжин ирсэн хүн	569	678	658	372	520	139.8
0-14 насны	162	179	194	90	150	166.7
15-54 насны	353	445	423	249	321	128.9
55 ба түүнээс дээш насны	54	54	41	33	49	148.5
Бүгдээс: аймгаар						
Булган	133	169	142	90	144	160.0
Улаанбаатар	221	224	193	121	156	128.9
Завхан	22	21	30	11	21	190.9
Хөвсгөл	33	35	32	15	34	2.3 ²
Сэлэнгэ	39	42	63	33	29	87.9
Архангай	30	34	34	9	30	3.3 ²

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр авав.

Тайлбар: ²-Дахин их



ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Нийт үзлэг, хүн	145 868	151 465	150 829	154 922	168 203	108.6
урьдчилан сэргийлэх үзлэг	45 593	46 975	53 705	55 576	54 347	97.8
Нэг хүний эмнэлэгт үзүүлсэн тоо	1.55	1.49	1.48	1.50	1.61	107.3
Эмчлэгдсэн хүний тоо	5 785	5 776	6 469	6 844	7 366	107.6
Ор хоног	44 317	42 570	46 354	49 203	51 221	104.1
1 хүний эмчлүүлсэн дундаж хоног	7.66	7.37	7.17	7.19	6.95	96.7
Сэргийлэх тарилга, хүн	4 072	4 078	4 434	4 191	4 260	101.6
Хамрагдалтын хувь	98.3	98.3	98.0	99.2	99.2	0.0

ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ

	Үйлчлүүлсэн хүний тоо					$\frac{2020}{2019}=\%$	Үйлчилгээний орлого (сая.төг)					$\frac{2020}{2019}=\%$
	2016	2017	2018	2019	2020		2016	2017	2018	2019	2020	
БҮГД	19 960	19 600	24 493	31 123	26 079	83.8	603.2	1336.9	1198.1	912.4	2054.3	2.3²
Хиймэл шүд	202	99	111	42	39	92.9	6.7	4.8	7.6	2.4	3.6	150.0
Шүд эмчилгээ	4 731	4 746	5 765	7 981	5 912	74.1	122.6	107.8	140.8	167.1	220.3	131.8
Бусад эмчилгээ	15 027	14 755	18 617	23 100	20 128	87.1	473.9	1224.3	1049.7	742.9	1830.4	2.5 ²

Тайлбар: ² -Дахин их


ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	2016		2017		2018		2019		2020		Харьцуулсан хувь	
	Бодит тоо	Үзүүлэлт	Бодит тоо	Үзүүлэлт	Бодит тоо	Үзүүлэлт	Бодит тоо	Үзүүлэлт	Бодит тоо	Үзүүлэлт	Бодит тоо	Үзүүлэлт
1000 хүнд ногдох												
Амаржсан эх	611	6.5	542	5.3	692	6.8	623	6.0	635	6.1	101.9	0.1
Төрөхийн улмаас эндсэн эх (100 000 амьд төрөлтөд ногдох)	-	-	-	-	-	-	-	-	-	-		
Нас баралт	142	1.5	122	1.2	124	1.2	144	1.4	124	1.2	86.1	-0.2
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	11	17.9	3	5.5	5	7.2	7	11.1	7	11.0	100.0	-0.1
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1	1.6	-	-	1	1.4	-	-	2	3.2		
10 000 хүнд ногдох												
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	513	54.5	128	12.6	194	19.1	205	19.9	220	21.1	107.3	1.2
Цусан суулга	2	0.2	5	0.5	21	2.1	27	2.6	2	0.2	7.4	-2.4
Сальмонеллэз	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халдварт шар	2	0.2	7	0.7	2	0.2	1	0.1	3	0.3	3.0 ²	0.2
Бруцеллез	-	-	-	-	1	0.1	-	-	-	-	-	-
Халдварт мэнэн	-	-	-	-	-	-	-	-	1	0.1		
Сүрьеэ	19	2.0	15	1.5	17	1.7	14	1.4	24	2.3	171.4	0.9
Суулгалт халдвар	-	-	2	0.2	1	0.1	20	1.9	4	0.4	20.0	-1.6
Хамуу	-	-	1	0.1	-	-	-	-	-	-		
Заг хүйтэн	2	0.2	5	0.5	9	0.9	8	0.8	25	2.4	3.1 ²	1.6
Тэмбүү	36	3.8	25	2.5	30	3.0	33	3.2	48	4.6	145.5	1.4
Мөөгөнцөр	25	2.7	24	2.4	36	3.5	29	2.8	15	1.4	51.7	-1.4
Трихоманаз	36	3.8	27	2.6	31	3.0	34	3.3	27	2.6	79.4	-0.7
Кандид	-	-	-	-	10	1.0	16	1.6	26	2.5	162.5	0.9
Салхинцэцэг	2	0.2	7	0.7	27	2.7	18	1.7	43	4.1	2.4 ²	2.4
Гахай хавдар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хоолны хордлого	-	-	-	-	6	0.6	3	0.3	1	0.1	33.3	-0.2
Херпес вируст цэврүүт дертитит	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гар, хөл, амны өвчин	6	0.6	8	0.8	2	0.2	2	0.2	1	0.1	50.0	-0.1
Ёлом	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Улаан бурхан	380	40.3	-	-	-	-	-	-	-	-		
Улаанууд	2	0.2	-	-	-	-	-	-	-	-		
Бүслүүр үлд	-	-	2	0.2	1	0.1	-	-	-	-		
Улаан эсэргэнэ	1	0.1	-	-	-	-	-	-	-	-		
Эмнэлгийн дотоод халдвар	48	5.1	-	-	-	-	-	-	-	-		
<i>нярайн бактерит үжил</i>	-	-	-	-	-	-	-	-	-	-		

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээгээр авав.

Тайлбар: ²-Дахин их

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД




БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Бүртгэгдсэн гэмт хэрэг - бүгд	154	189	250	181	155	85.6
Хэрэг бүртгэлтийн хэрэг (эзэнгүй хэрэг)	48	63	185	169	136	80.5
Илрээгүй хэрэг	18	22	146	98	76	77.6
Илрүүлэлтийн хувь	62.5	65.1	21.1	42.0	44.1	2.1
Хэргийн өнгөөр:						
Хүнийг алах	1	1	-	1	-	
Хүчиндэх	7	4	4	5	5	100.0
Танхайрах	1	7	
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	61	75	76	45	70	155.6
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	11	9	5	9	3	33.3
Хулгайлах	45	56	99	54	32	59.3
иргэдийн өмчийн хулгай	40	51	95	49	32	65.3
Малын хулгай	1	3	-	3	3	100.0
Бусдын эд хөрөнгө булаах	-	1	
Дээрэмдэх	3	4	14	2	3	150.0
Залилах, хөрөнгө завших	13	8	28	29	25	86.2
Авлигын хэрэг	1	-	-	1	-	
Орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	-	1	-	-	
Бусад	10	21	23	32	14	43.8
Согтуугаар үйлдэгдсэн хэрэг	66	83	34	44	51	115.9
Хүнд гэмт хэрэг	16	19	77	56	40	71.4
Гэмт хэргийн улмаас:						
Нас барсан	7	4	5	11	6	54.5
Гэмтсэн	63	95	67	53	77	145.3
Учирсан хохирол, сая төг	279.5	351.2	426.1	848.0	430.8	50.8
иргэдэд учирсан хохирол	279.5	351.2	239.4	811.2	428.3	52.8
нөхөн төлүүлсэн	205.3	102.1	105.2	109.7	138.6	126.3
битүүмжилсэн хөрөнгө	2.5	32.0	9.5	8.0	8.8	110.0
Гэмт хэрэг үйлдэгсэд	123	184	105	83	79	95.2
18 хүртэлх насны хүүхэд	2	11	9	8	1	12.5
Эрхэлсэн тодорхой ажилгүй	79	105	65	53	40	75.5
Согтуугаар	61	90	53	45	54	120.0
Гэмт хэрэг бүлэглэн үйлдэгч	20	47	17	12	6	50.0
Эрүүлжигдсэн хүн	1 152	1 671	1 001	804	738	91.8
Захиргааны шийтгэлээр баривчлагдсан	105	97	167	209	210	100.5
18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг	23.8	27.1	36.8	26.5	22.7	-3.8
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	319	266	433	360	391	108.6
Эрх хасагдсан	267	241	329	304	317	104.3

Эх үүсвэр: Цагдаагийн газрын мэдээгээр авав.

Тайлбар: ... -Хуулийн заалт байхгүй болсон.



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, сая.төгрөг

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Бүгд	2 333.1	2 614.9	3 289.5	3 183.4	3 568.0	112.1
Халамжийн тэтгэвэр	666.2	679.5	721.6	763.0	887.6	116.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	291.2	326.7	355.6	241.1	480.7	199.4
Ахмад настныг асарч буй иргэнд	146.1	164.4	173.3	104.9	222.6	2.1 ²
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд	130.2	148.6	167.9	120.6	240.7	199.6
Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид	10.4	11.3	11.4	11.6	12.2	105.2
Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	3.8	2.4	3.0	3.8	5.0	131.6
Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	0.5	-	-	0.2	0.2	100.0
Хүүхэд, төрөл садангүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ асран хамгаалж байгаа	0.2	-	-	-	-	-
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	202.2	224.9	254.2	186.1	219.1	117.7
Байнгын асаргаа шаардлагатай иргэнд	79.4	82.8	74.3	35.5	28.3	79.7
16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	94.6	119.6	145.7	130.6	174.4	133.5
3 ба түүнээс дээш тооны (14 хүртэлх насны) хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа	2.6	3.7	0.2	-	-	-
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	10.0	8.0	16.0	14.0	8.0	57.1
4 хүртлэх насны 3 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа иргэнд	-	-	-	-	-	-
Нэг удаагийн тусламж	1.2	1.2	-	-	-	-
Хорих ангиас суллагдсан өөрийн орон гэргүй иргэнд	3.6	-	12.0	1.2	3.6	3.0 ²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа	3.6	6.0	1.2	-	2.4	-
Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа	7.2	3.6	4.8	4.8	2.4	50.0
4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны Хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэнд	-	-	-	-	-	-
Ахмад настай, ХБИ-дэд олгосон тусламж, хөнгөлөлт	151.3	102.5	159.7	137.4	115.6	84.1
Ахмад настанд үзүүлсэн	122.1	74.9	126.1	100.0	86.7	86.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн	29.2	27.6	33.6	37.4	28.9	77.3
Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт	1 002.8	1 267.5	1 793.0	1 855.8	1 848.8	99.6
Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж	279.3	247.5	108.6	698.0	33.7	4.8
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон мөнгөн тусламж	705.8	704.4	711.5	737.7	725.8	98.4
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт	17.7	21.1	25.6	27.6	30.3	109.8
Насны хишиг	-	294.5	315.0	341.5	347.3	101.7
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	-	-	612.4	-	416.9	-
Цалинтай ээж хөтөлбөр	-	-	-	-	226.5	-
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	-	-	19.9	51.0	68.3	133.9
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	19.4	13.8	5.4	-	16.2	-

Тайлбар: ² -Дахин их

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГСАД, хүний тоо

	2016	2017	2018	2019	2020	$\frac{2020}{2019}$ %
Бүгд	17 096	20 957	26 685	26 020	35 239	135.4
Халамжийн тэтгэвэр	1 799	1 675	1 664	1 889	1 650	87.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 725	1 819	1 750	1 701	1 837	108.0
Ахмад настныг асарч буй иргэнд	873	931	893	832	939	112.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд	780	823	795	795	839	105.5
Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид	51	54	50	59	42	71.2
Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	17	11	12	14	16	114.3
Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	3	-	-	1	1	100.0
Хүүхэд, төрөл садангүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ асран хамгаалж байгаа	1	-	-	-	-	-
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	1 627	1 720	1 611	1 302	850	65.3
Байнгын асаргаа шаардлагатай иргэнд	1 321	1 377	1 248	941	471	50.1
16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	265	298	335	351	368	104.8
3 ба түүнээс дээш тооны (14 хүртэлх насны) хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа	23	30	2	-	-	-
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	5	4	9	7	4	57.1
4 хүртлэх насны 3 ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа иргэнд	-	-	-	-	-	-
Нэг удаагийн тусламж	1	1	-	-	-	-
Хорих ангиас суллагдсан өөрийн орон гэргүй иргэнд	3	-	10	1	3	3.0 ²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа	3	6	3	-	2	-
Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа	6	4	4	2	2	100.0
4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны Хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэнд	-	-	-	-	-	-
Ахмад настай, ХБИ-дэд олгосон тусламж, хөнгөлөлт	3 840	4 208	5 027	5 009	2 779	55.5
Ахмад настанд үзүүлсэн	3 687	3 958	4 721	4 569	2 576	56.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн	153	250	306	440	203	46.1
Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт	8 055	11 495	16 601	16 119	28 087	174.2
